

Хэсэг 12.

Бурханы сургаалийг бүтээхийн аньс нь энэрэн нигүүлсэхүйн сэтгэлийг анхааран авахуй

Ажаа ринбүчи

Редакторын тайлбар: VIII Ажаа ринбүчи Лувсан Түвдэнжигмэжамц нь Төвдийн бурханы шашны их багш, гүн ухаантан, бясалгагч, Далай ламын тэргүүлэгч Гэлүгвийн урсгалыг үндэслэгч Богд Зонховын эцгийн хувилгаан хүн юм. 1950 онд төрсөн тэрбээр эдүгээ амьд сэрүүн ахуй Монголын хамгийн нэртэй хутагт билээ. Амдогийн Гүмбүм хийдэд суралцаж хожим тэр хийдийнхээ тэргүүн болсон бөгөөд Хятадын соёлын хувьсгалыг биеэрээ туулж олон арван жилийн туршид Хятад дахь бурханы шашныг уйгагүй дэмжин ажиллаж ирсэн нэгэн билээ. 1998 онд Хятадууд жинхэнэ дүрийг нь гэрийн хорионд хийж өөрсдийн “сольж” тодруулсан Банчин богдын багш болгох оролдлого хийх үед тэрбээр гадаадад дүрвэн гарчээ. Ингэснээр тэрбээр Хятадаас дүрвэн гарсан томоохон лам нарын нэг болсон юм. Түүний дурдатгал ном нь “Амь гарсан луу: Хятадын захиргаан дахь Төвдийн ламын 40 жилийн түүх” нэртэйгээр хэвлэгджээ.

Ажаа ринбүчи энэхүү илтгэлдээ өнөөгийн Монголын бурханы шашны хүрээнд бурханы шашны нийгүүлсэл ямар үүрэг, ач холбогдолтой болохыг энгийн боловч гүн нарийн утгатайгаар харуулсан болно. Тэрбээр нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагааны ач холбогдол, орчин үеийн материаллаг үзлийн бэрхшээл, нийгмийн нээлттэй-үзэл санааны чухал болохыг дурдаж, нигүүлсэл нь зөвхөн бясалгал, залбиралын зорилгоор бус, бас өдөр тутмын амьдрал, хэрэглээнд хэрэглэх нь чухал болохыг өгүүлжээ.

Бурханы сургаалийн охь шим нь билиг билгүүн, энэрэн нигүүлсэхүйн сэтгэл ажгуу. Төвд, Монгол тэргүүтэн

алин ч хүмүүн энэхүү хоёр сэтгэлийн эрдмийг зүрх сэтгэл, оюун санаандаа төрүүлэхийг олон зууны турш эрхэмлэн чухалчилсаар иржээ. Анагаах ухаан, зурхайн ухаан, сүм хийд, суврага бүтээх зэрэг урлахуйн ухааныг судлах нь зөвхөн оюун ухааны хөгжилд хамаарах бус мөнхүү эд өлгийн хөгжилд ч хамаарах билээ. Үүний адил билгэ билгүүнийг төрүүлэх нь үүнтэй агаар нэгэн юм. Энэхүү өгүүллэгт би билгэ билгүүний тухай бус харин түүнтэй хослон эзэмших энэрэхүй сэтгэлийн тухай өгүүлэх болно. Бурханы сургаалд нигүүлсэхүйн сэтгэлийг хамаг амьтныг энэрэн хайрлаж амьтны амар амгаланг бүтээхийг хэлдэг. Харин эдүгээ нийгэмд Бурханы сургаалыг бүтээхүйд энэхүү сэтгэлийг төрүүлэхийн тус эрдэм юунд орших вэ?

Мутартаан илд эрхшээн эзэн богд Чингис Хаан Ази, Европын өргөн уудам нутгийг нэгэн цагт эзлэн дагуулжээ. Эзэн Богдын суу алдар дэлхийд түгэн эдүгээ ч Монголчуудын огших омогшил, хүсэх мөрөөдөл байсаар байна. Хэдий ийм боловч эдүгээ хорин нэгдүгээр зуунд бусдыг байлдан дагуулах нь улсын хүчин эсвэл газар нутаг өргөн уудмаас эс хамаарах болжээ. Хүмүүс өөрийн өссөн төрсөн нутаг, амраг садангаа орхиод гадаад улс руу одох болсон байна. Ямар шалтгаанаар вэ? Газар нутгийн уудам, улс орны хүчин тэдний сэтгэлийг татсан уу? Үнэндээ үгүй юм. Тэдний сэтгэлийг эрх чөлөө, эрх тэгш байдал болон хуулийг хүндлэн дээдлэх ёсон байлдан дагуулжээ. Тухайн орнуудад хувь хүний амьдралын үнэ цэнийг дээдлэн хүндэлдэг тул өөрт буй хүчин чадал, авьяас чадварыг хөгжүүлэхээр хүмүүс очжээ. Хүнийг эрхэмлэн дээдлэх нь үнэндээ энэрэн нигүүлсэхүйн сэтгэлийг нийгэмд хэрэгжүүлж байгаа болно. Орчин үеийн иргэншсэн нийгмийн гишүүдэд чухамхуу ямар зүйл хэрэгтэй байна түүнийг л мөнхүү Бурханы сургаалыг дээдлэгчид эрэлхийж ирсэн нь ямар ч эргэлзээгүй юм.

ЗХУ болон БНХАУ-ын төрийн дэглэм дэлхий дахинд

нэн ялангуяа дорнын иргэншилд үлэмжхэн хор хөнөөлтэй үйлийг үйлдсэн нь бидэнд тодорхой. Монголд ч хар сүүдрээ тусгасан билээ. Эдүгээ Монгол улс орчин үежилтийг эрэлхийж буй үед Монгол улсын улс төрчид, эдийн засагчид, бизнес эрхлэгчид, олон улс дамнасан корпорациуд болон бусад хүмүүс ихэнхидээ эд өлгийн баялгийг бүтээхийг илүүтэй үзэж байна. Энэхүү байдал нь Монголчуудын бурханы сургаалиас улбаатай үзэл бодол, гүн ухаанд ноцтой сөрөг нөлөө үзүүлж байна. Чухамдаа аль ч нийгэм бусдыг энэрэн нигүүлсэхэд анхаарлаа эс хандуулах аваас тухайн нийгмийн хүмүүсийн амьдралын утга учир нь алдагдан нийгмийн эрхэмлэн хүндлэх ёс зүй, суртахуунд гүнзгий хор хөнөөлийг учруулна.

Нигүүлсэхүйн сэтгэл, хандлага нь гүн гүнзгий бөгөөд тус эрдэм их. Улс төрчид энэхүү энэрэн нигүүлсэхүй, бусдыг бодохын зарчмыг баримтлан нийгмийн сайн сайхныг хадгалан хамгаалах, нийгмийн тэгш бус байдлыг арилгах хууль, дүрэм журмын төслийг боловсруулах нь зүйтэй. Залуу хойч үе маань цэвэр агаар, цэнгэг ус, байгаль орчны тогтвортой байдлыг хадгалахын тулд асрал энэрэлийн сэтгэлийн дүрэм журмыг дагах хэрэгтэй. Уул уурхайн салбарынхан энэрэхүйн зарчмыг барин эд баялгийг хураахын сацуу үзэсгэлэнт байгаль дэлхийд ноцтой хор хөнөөл учруулахаас үргэлж сэрэмжлэн зайлсхийх хэрэгтэй. Нигүүлсэхүй сэтгэл нь зөвхөн оюун санааны ертөнцөд тус эрдэмтэйн адил нийгэм өөрчлөгдөхийн сацуу уг өөрчлөлтөөс хамаарах эд өлгийн ертөнцөд хэрэгтэй. Нигүүлсэхүй сэтгэл нь хүмүүний бүхий л амьдрал хийгээд байгаль орчинд тустай бөгөөд нийгэм эрүүл, зөв хөгжих түлхүүр болно.

Хэрхэн бид энэрэн нигүүлсэхүй сэтгэлийг тэтгэн дэвжээх вэ? Хэрхэн илүү хүмүүнлэг нийгмийг цогцлон бүтээх вэ? Бурханы сургаалийг дагагчид мэдээжийн хэрэг сүм хийд барин уламжлалт сургаал номыг дэлгэрүүлэхийг санал болгох нь лавтай. Уламжлалт соёлоо хадгалан хамгаалах нь бидний

үүрэг мөнөөс мөн. Гэвч энэ нь урьдын зүйлийг дахин давтана гэсэн үг хараахан биш юм. Бид шинээр үүсэн гарч буй үзэл бодлыг тусган авч хүн төрөлхөтөнд тустай үйлийг үйлдэх нь зүйтэй. Урьд цагт сүм хийд нь эргэл мөргөл, бясалгал үйлдэх, судар номонд суралцах орон байсан. Эдүгээ сүм хийд бүхий л төрлийн хүмүүс бурханы сургаал номыг танин мэдэх, бясалгалд суралцахад үүд хаалгаа нээлттэй байлгах хэрэгтэй. Сүм хийд орон гэргүй хүмүүст орон гэр нь, эд хөрөнгөөр дутмаг нэгэн боловсрол эзэмшихэд нь тус дэм болох улмаар хүмүүс өвөр хоорондоо учран золгож өөрсдийн амьдралд тохиолдож буй саад бэрхшээлээ даван туулах арга замаа олоход нь тус болох төв байх нь зүйтэй.

Өнгөрсөн зуунд Монгол улсад өрнөсөн улс төрийн эрс өөрчлөлтөөс шалтгаалан нэгэн үес олон хүмүүс ажил, гэр оронгүй болж өвчин зовлонгоо эдгэрүүлэх боломжгүй болсон. Нийгмийн хүнд хэцүү энэхүү байдлыг харан бурханы сургаалийг дагагчид мөнхүү бусад шашны хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажил эрхлэх, ядуу айлын хүүхдүүд сурч боловсрох боломж олгон мөнхүү өнчин хүүхдүүдийг асран хамгаалах газрыг байгуулж эхэлсэн. Энэхүү үйлс нь энэрэл нигүүлсэхүйн сэтгэлийн үр билээ.

2009 онд Монгол улсад би очсон бөгөөд тухайн үеийн нөхцөл байдлыг харан хэрэв малчин ард бэлчээрээ алдвал, өрхийн тэргүүн ажилгүй болвол, гэрийн эзэгтэй гэр бүлээ тэжээх хоол хүнсгүй болвол, үр хүүхэд нь эцэг эхээ энэрэн хайрлах боломжгүй болвол бид Зургаан барамид, Хутагтын найман гишүүн хэмээн үргэлжид өгүүлэхийн хэрэг юунд орших вэ хэмээн бодох болсон.

Сүүлийн жилүүдэд би хүмүүнлэгийн ажил болон эмнэхүйн ажилд ихээхэн анхаарал тавин ажиллаж байна. Хэдийгээр Монгол улсын засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагууд эмнэлгийн нөхцөл байдлыг сайжруулах талаар ихээхэн анхаарал тавин холбогдох ажлууд

хийж буй боловч нэжгээд эмнэлгүүдийн нөхцөл байдал хуучны байдалтай, шинжилгээ хийлгэх, эмчилгээ хийлгэхийн тулд хүмүүс Солонгос, Тайланд болон Хятад улс руу явсаар байна. Ойрмогхон хүмүүстэй уулзаж Монголд хамгийн хэрэгцээтэй зүйлийн тухай асуухад Монголд орчин үеийн эмнэлгийн тоног төхөөрөмж, эрдэм мэдлэг төгс эмнэлгийн эмч, ажилтнууд хэрэгтэй байна хэмээн хэлсэн. Монгол улсад орчин үеийн эмнэлгийн тогтолцоо хэрэгтэй байна.

Би Гүмбүм хийдэд байх үед бид Улаан загалмайн нийгэмлэгийг байгуулсан. Бид Төвдийн анагаах ухааны эмнэлэг байгуулан хүмүүнлэгийн ажил хийж байсан. Цас ихээр унах, газар хөдлөх зэрэг байгалийн гамшиг тохиолдох үед бид ойролцоох хот тосгодоор яван тусламж үзүүлдэг байсан. Мөн хандив цуглуулах, хувцас, эм түгээх болон амь үрэгдсэн хүмүүсийн хойтод зориулан ном уншиж байсан.

Дээр дурьдсан хүмүүнлэгийн ажил хийж байсан туршлага болон Монгол улсын засгийн газрын дэмжлэг, анд нөхөд, номын садан нөхдийн тус дэмжлэгээр Улаанбаатар хотноо Велнесс Плас хэмээх эмнэлэг барихаар зорьж байна. Хэрэв боломж нөхцөл бүрдэх аваас уг эмнэлэг нь иж бүрэн үйлчилгээ үзүүлэх эмнэлэг болно. Бид хөдөө орон нутгийн хүмүүсийг хамааруулан нийт олон нийт, төлбөрийн чадвар үгүй хүнд ч үйлчлэх зорилготой. Алс хязгаар нутагт буй хүмүүст эмнэлгийн тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэхэд чиглэх болно.

Энэрэн нигүүлсэхүй нь бясалгал үйлдэх, ерөөл ном уншихаар эс хязгаарлагдана. Нигүүлсэхүйн сэтгэлийг өөрийн сэтгэлд өдөр тутам дадуулах хэрэгтэй. Энхжингийн орон нь зөвхөн сэтгэлд бясалган бодох орон бус харин ч бид орчлон хорвоог энхжингийн орон болгох үйлсийг бүтээх хэрэгтэй. Бурханы сургаалийг дагагчийн хувьд эдүгээ энэрэл нигүүлсэхүйн сэтгэлийг дадуулахийн тус утга нь чухамдаа энэхүү л үйлсийг түгээн дэлгэрүүлэхэд оршино.